



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 7/180

Дадал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 дахь заалт, Засгийн газрын "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" 110 дугаар тогтоолын 2.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 40 дүгээр тушаалаар баталсан "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Ш.Мөнххуяг	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга	Б.Урансайхан	(Газрын даамал)
Гишүүд	Д.Батзориг	(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
	Ч.Бат-Эрдэнэ	(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
	Э.Баасанхүү	(Баян-Овоо багийн Засаг дарга)
	А.Азжаргал	(Онон багийн Засаг дарга)
	А.Анар	(Балж багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Г.Ган-Эрдэнэ	(Агац багийн Засаг дарга)
	М.Эрдэнэбулган	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2.Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах бүх ангиллын газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хамгаалах саналыг газар зохион байгуулалтын систем ашиглан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас санал авч багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, холбогдох газарт хүргүүлж ажиллахыг газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000415